

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд доор дурдсан агуулга бүхий дараах хэсэг нэмсүгэй:

1/29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дахь хэсэг:

“29.4. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө энэ хуулийн 29.5-д заасан ангилалд хамаарах системд техник, эдийн засгийн үндэслэлийг хийлгэж ирүүлнэ.

29.5. Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн гишүүн хамтран тогтооно.”

2 дугаар зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө” гэсний өмнө “энэ хуулийн 29.4-т зааснаас бусад” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг